

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын
2024 оны ... дугаар сарын-ны өдрийн.....
дугаар албан бичгийн дугаар хавсралт

2024 ОНЫ БАЙГУУЛЛАГЫН ЖИЛИЙН УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭ
/2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/

2024 оны 12 дугаар сарын 24

Улаанбаатар хот

Д/д	Бүлэг	Үзүүлэлт	Гүйцэтгэл, хүрсэн түвшин, үр дүн	Хувь
1	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан заалтуудын хэрэгжилт /Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын 5-р хавсралт, журмын 6.3-т заасан аргачлалаар тооцно/	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан нийт 79 арга хэмжээний хэрэгжилтийг Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын 6.2-т заасан аргачлалаар нэгтгэн, дүгнэж 2024 онд нийт 19 удаа Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын цахим систем /erp.ulaanbaatar.mn/-ээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний газарт хүргүүлэн ажилласан. Хэрэгжилтийн дундаж хувь 100 байна.	100
2	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	2.“Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал. /Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын 6.2-т заасан аргачлалаар тооцно/.	“Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын 6.2-т заасан аргачлалаар нэгтгэн дүгнэж, 2024 онд нийт 3 удаа Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын цахим систем /erp.ulaanbaatar.mn/-ээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний газарт хүргүүлэн ажилласан. Нийт 3 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 100 хувь байна.	100
3	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Байгууллагын “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний хэрэгжилт, үр дүн /Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын 6.2-т заасан аргачлалаар тооцно/.	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын 6.2-т заасан аргачлалаар “Нийтийн тээврийн газрын 2024 оны гүйцэтгэлийн тайлан”-г 2024 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэж, хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн. Нийтийн тээврийн бодлогын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын баримт бичгийн хүрээнд 2 зорилго, 9 зорилт, 72 арга хэмжээ төлөвлөгдсөн байна. Нийт 2 зорилго, 11 зорилт, 72 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь 98.1 байна. Үүнээс 69 арга хэмжээ 100 хувь, 2 арга хэмжээ 70 хувь, 1 арга хэмжээ 30 хувь байна.	100

Д/д	Бүлэг	Үзүүлэлт	Гүйцэтгэл, хүрсэн түвшин, үр дүн	Хувь
			Тус газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж хувь 97,7 байгаа нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3-т заасан үнэлгээний арга зүйгээр “Үр дүнтэй” (зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан) үнэлгээтэй байна.	
4	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлт ийн үнэлгээ	2.Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө болон нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт, төсвийн гүйцэтгэл.	Тус газар нь 2024 онд батлагдсан төсвийн хуваарийн дагуу үндсэн үйл ажиллагааны орлого 3,792,7 сая төгрөг төвлөрүүлэхээс 12 дугаар сарын 18-ний өдрийг хүртэлх хугацааны гүйцэтгэлээр 3,633,3 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 272,4 сая төгрөг төвлөрүүлэхээс 331,2 сая төгрөг төвлөрүүлсэн. Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлэхээр 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн бэлэн мөнгөөр зорчих иргэдийн төлбөрийг мөнгөний хайрцагт хийлгэж хэвшсэнээр 12 дугаар сарын 19-ний өдрийг хүртэлх хугацаанд бэлэн мөнгөний орлого 1,710,1 сая төгрөг, Улаанбаатар смарт ХХК-ий суурилуулсан хайрцагны орлого 331,2 сая төгрөгийг тус газрын 100200051055 тоот дансанд төвлөрүүлсэн байна. Хүү торгуулийн орлого 2024 онд 100.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 12 дугаар сарын 19-ний өдрийг хүртэлх өссөн дүнгээр 100.2 сая төгрөг төвлөрч төлөвлөгөөний гүйцэтгэл 100 хувьтай байна.	100
5	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	1.Байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн./Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын 9-р хавсралт, журмын 6.2-т заасан аргачлалаар тооцно/.	Цаг үеийн мэдээ, мэдээллийг ил тодоор мэдээлэх, нийтэд түгээх ажлыг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран зохион байгуулан ажилласан. Байгууллагын албан ёсны цахим хуудас /www.transport.ub.gov.mn/ болон https://www.facebook.com/transport.ub.gov.mn олон нийтийн сүлжээнд 2024 онд нийт 1137 мэдээ, мэдээллийг бэлтгэн байршуулж иргэдийг мэдээллээр ханган ажилласан. Үүнээс постер 75, видео 45, фото 82, ярилцлага 10, хөрөг ярилцлага 5, баннер 4, нийтийн тээврийн үйлчилгээтэй холбоотой 875 мэдээ, мэдээлэл байна.	100
6	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	2.Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангасан байдал буюу шилэн дансны хөтлөлтийн байдал, үр дүн.	Байгууллагын 2023 оны 12 дугаар сар, энэ оны 01-10 дугаар саруудын нийт 171 мэдээллээс хугацаандаа мэдээлсэн 137, хүлээгдэж буй гүйцэтгэлээр 28 мэдээлэл хавсралт файлуудын хамт шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд /shilendans.gov.mn/ 3 дэд цэсээр байршуулснаас, хугацаа хоцорсон 6 мэдээлэл байна.	100

Д/д	Бүлэг	Үзүүлэлт	Гүйцэтгэл, хүрсэн түвшин, үр дүн	Хувь
			Энэ оны жилийн эцсийн байдлаар тухайн газраас худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй болно.	
7	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	3.“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулсан байдал. /Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын 6.2-т заасан аргачлалаар тооцно/.	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын 6.2-т заасан аргачлалаар “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн, дүгнэж 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 01/01/3217 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний газарт хүргүүлсэн. Нийт 11 арга, хэмжээний хэрэгжилтийн дундаж 86,6 хувь байна.	100
8	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	4.Улс, Нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, зээл тусламж болон өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын төлөвлөлтийн оновчтой байдал, гүйцэтгэл, чанар, үр дүн	Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1224 дугаартай захирамжаар улсын төсвийн хөрөнгөөр нийтийн тээврийн автобус худалдан авахад 183,438.6 сая төгрөг батлагдсан. Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр их багтаамжийн дизель хөдөлгүүртэй 600 автобус худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахаар 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс 1 сарын хугацаатай олон улсын нээлттэй тендер зарлан, Yutong Bus Co.,Ltd шалгарч Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр НЗДТГ/202310014 дугаартай “Нийтийн тээврийн автобус нийлүүлэх гэрээ” байгуулагдсан. Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1458 дугаартай захирамжаар чанар, стандарт, шаардлагад нийцсэн их багтаамжийн автобусыг холбогдох хууль, журмын дагуу хүлээж авах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Эдгээр автобусыг Улаанбаатар хотын Хөгжлийн Корпорац ХК-аас нийслэлийн Засаг даргын 2024 оны А/86, А/161 дүгээр захирамжийн дагуу нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч Нийслэлийн өмчит 2 аж ахуйн нэгжид 267, хувийн хэвшлийн 10 аж ахуйн нэгж байгууллагад 333 автобусыг хуваарилах ажлыг “Нийтийн тээврийн хэрэгслийг төлбөртэй ашиглуулах гэрээ”-г байгуулсны үндсэн дээр шилжүүлэн өгсөн. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, “Юүтонг бус” ХХК нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36.1.3 дах заалтад заасныг баримтлан нэг эх үүсвэрээс худалдан авах аргыг хэрэглэж талуудын хооронд	100

Д/д	Бүлэг	Үзүүлэлт	Гүйцэтгэл, хүрсэн түвшин, үр дүн	Хувь
			2024 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн №НЗДТГ/202310014-02 дугаартай “Нийтийн тээврийн автобус нийлүүлэх нэмэлт гэрээ” байгуулсан. Санхүүжилтийг “Нийтийн тээврийг хөгжүүлэх сан”-д хуримтлагдсан хөрөнгийн эх үүсвэрээс ZK6186HG маркийн их багтаамжийн 31 угсраа автобусыг худалдан авах 22,9 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн.	
9	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	5.Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Нийслэлийн Засаг зөвлөлийн хурлын тэмдэглэл, Нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, үр дүн	Нийслэлийн нийтийн тээврийн салбарын ажлыг эрчимжүүлэх Нийслэлийн Засаг даргын 01 албан даалгаврыг хэрэгжүүлэх 10 арга хэмжээний хэрэгжилтийг нийт 2 удаа, Нийслэлийн Засаг даргын нийт 9 захирамжийн 24 арга хэмжээний хэрэгжилтийг 11 удаа Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын цахим систем /erp.ulaanbaatar.mn/-ээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлэн ажилласан. Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн 21 удаа хуралдаж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас өгсөн 81 арга хэмжээний хэрэгжилтийг Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын цахим систем /erp.ulaanbaatar.mn/-ийн Хяналт шинжилгээ, үнэлгээ цэсээр тайлагнан ажилласан. Нийт 106 үүрэг даалгаврын хэрэгжилтийн дундаж хувь 100 байна.	100
10	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	6.Нийслэлийн Засаг даргаас Засгийн газрын гишүүд, салбарын сайд нартай байгуулсан батламж, санамж бичиг, хамтран ажиллах гэрээнд заасан зорилтуудын хэрэгжилт, үр дүн	Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нар зам тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд батлагдсан 2024 оны нарийвчилсан төлөвлөгөөний хэрэгжилтийг 2024 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэн 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 02/01/1519 дугаартай албан бичгээр, 2024 оны жилийн эцсийн байдлаар 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 01/01/3099 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Зам, тээврийн яаманд тус тус хүргүүлэн ажилласан. Нийт 8 арга, хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь 88.7 байна.	100
11	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	7.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн.	1.Азийн хөгжлийн банкны төсөл хэрэгжүүлэгч Инфокон ХХК-ийн төслийн мэдээллийн сангийн шинэчилсэн программыг турших ажиллагаа хийгдэж байна. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 18 аж ахуйн нэгж, байгууллагын 47, такси, буухиа үйлчилгээний 12 аж ахуйн нэгж, байгууллагын 17 ажилтан албан хаагчдад мэдээллийн нэгдсэн санд нэвтрэх эрхийг олгуулсан.	100

Д/д	Бүлэг	Үзүүлэлт	Гүйцэтгэл, хүрсэн түвшин, үр дүн	Хувь
			2.“Авто үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн сан”-гийн программ хангамжийг хэрэглээнд нэвтрүүлж, 2024 онд www.autobox.mn сайтад нэвтрэх эрхээ авсан авто засварын үйлчилгээ эрхэлдэг 405 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 86662 автотээврийн хэрэгсэлд хийгдсэн засвар, үйлчилгээний мэдээллээ оруулан бүртгэлжүүлж хяналт тавьж ажилласан. Төрийн үйлчилгээний цахим портал www.e-mongolia.mn, Авто үйлчилгээний мэдээллийн сан www.autobox.mn веб сайтуудаар авто үйлчилгээний ангиллын гэрчилгээний хүсэлтийг цахимаар хүлээн авч байна. 3.Ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах “Түр” зөвшөөрөл хүссэн иргэн аж ахуйн нэгж байгууллагын холбогдох материалыг “Тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээний систем” www.smartcar.mn-ээр хүлээн авч 2024 онд нийт 6570 орчим тээврийн хэрэгсэлд В ангиллын 1530, С ангиллын 4840, СЕ ангиллын 200 тээврийн хэрэгсэлд тус тус олгосон. Төрийн Үйлчилгээний Цахим /ТҮЦ/ машинаар Нийслэлийн нутаг дэвсгэрт замын хөдөлгөөнд оролцох “ЕС” зөвшөөрөл нийт 15550 тээврийн хэрэгсэлд үүнээс В ангиллын 7515, С ангиллын 7260, СЕ ангиллын 775 тээврийн хэрэгсэлд тус тус олгосон. 4.Улаанбаатар хотын нийтийн тээврийн төлбөрийн менежментийг сайжруулах ажлын хүрээнд Ай Си Ти групп ХК-иас 1100 их багтаамжийн автобусанд зорчигч тоолох систем суурилуулахаар төлөвлөснөөс 1009 их багтаамжийн автобусанд суурилуулсан. 5.Тээврийн хэрэгслийн үзлэг оношилгоо, ажилчдын автобусны 1 дүгээр эгнээний зөвшөөрөл зэрэг үйлчилгээг “Smart car” аппликейшны тусламжтай олгодог байна. 6.Техникийн хяналтын үзлэгийн төлбөрийг “Qpay” төлбөр тооцооны системээр төлөх бэлтгэл ажлыг хангасан.	
12	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	3.Төрийн захиргааны албан хаагчдын ажлын гүйцэтгэл, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэсэн байдал	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 81 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/443 дугаар захирамжаар 350 орон тоотойгоор батлагдсаны дагуу тус газрын даргын 2024 оны “Байгууллагын бүтэц, ажил мэргэжлийн жагсаалт шинэчлэн батлах” тухай А/59 дүгээр тушаал батлагдаж, 2024 оны жилийн эцсийн байдлаар 167 албан хаагчтайгаа ажиллаж байна.	100

Д/д	Бүлэг	Үзүүлэлт	Гүйцэтгэл, хүрсэн түвшин, үр дүн	Хувь
			Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн “Үнэлгээний баг байгуулах” тухай А/145 дугаар тушаалаар тус газрын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх, хянаж баталгаажуулах, мэдээлэх үүрэг бүхий үнэлгээний багийг байгуулж, төрийн захиргааны 22, төрийн жинхэнэ албан хаагчтай адилтган жишиг байдлаар үнэлэгдэх төрийн үйлчилгээний 64 албан хаагчдаас ирүүлсэн гүйцэтгэлийн тайланг үндэслэн мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэн гарын үсэг зурж баталгаажуулан, 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр даргын зөвлөлийн хуралд танилцуулан маш сайн, хангалттай үнэлэгдсэн албан хаагчид урамшуулал олгон ажилласан.	
13	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	4.Байгууллагын үйл ажиллагааны зардал хямдруулах, төсөв хэмнэх чиглэлээр зохион байгуулж, үр дүнд хүрсэн бодитой ажил	Нийтийн тээврийн салбарын парк шинэчлэлтийн хүрээнд нийлүүлэгдсэн автобуснуудын даатгалын зардалд 2.9 тэрбум төгрөгийн төсөв батлагдсанаас YUTONG маркийн 589 автобус, Каунти маркийн 47 автобус, YUTONG маркийн угсраа 31 автобусны даатгалын зардалд 1.8 тэрбум төгрөгийг зарцуулж 1.1 тэрбум төгрөгийн хэмнэлтийг гаргасан. Нөхөн олговрын санхүүжилтээс 13.9 тэрбум төгрөгийг хэмнэж, үүнээс орлого, зарлагын санхүүжилтийн зөрүү рүү шилжүүлсэн 12.3 тэрбум төгрөг шилжүүлж нийт 1.6 тэрбум төгрөгийг төсвөөс бодитоор хэмнэсэн.	
14	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	6.Үндсэн чиг үүргийн биелэлт, үр дүнд дотоод аудит, хяналт эсвэл хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх, уг ажлын дүгнэлтийг үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлсэн байдал	Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/536 дугаар захирамжаар батлагдсан Нийтийн тээврийн бодлогын газрын “Дүрэм”-ээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг эхний хагас жилийн байдлаар 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 01/01/1589 дугаартай албан бичгээр гарган хүргүүлсэн. Нийт 18 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь 99 байна. 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын цахим систем /erp.ulaanbaatar.mn/-ээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, хөгжлийн бодлогын хэлтэст тус тус хүргүүлсэн. Нийт 18 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь 97 байна.	100

Д/д	Бүлэг	Үзүүлэлт	Гүйцэтгэл, хүрсэн түвшин, үр дүн	Хувь
15	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	7.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийг баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт /Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын 4 дүгээр хавсралтын дагуу үнэлнэ./	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийг баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг 2024 оны эхний хагас жилийн байдлаар гарган 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 01/01/1671 дугаартай албан бичгээр, 2024 оны жилийн эцсийн байдлаар гарган 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 01/01/3148 дугаартай албан бичгээр тус тус Төрийн албаны Зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн. Нийт 21 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь 100 байна.	100
16	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	8.Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн байдал	2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар нийт 4857 албан бичиг ирсэн. Үүнээс хариутай бичиг 526, хугацаандаа шийдвэрлэсэн 456, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 58, хугацаа хэтэрч шийдвэрлээгүй 1 албан бичиг байна. Шийдвэрлэлтийн дундаж хоног 4.96, шийдвэрлэлтийн хувь 95.27 байна.	100
17	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	9.Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал.	2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар нийт 3632 өргөдөл, гомдол ирснээс хугацаандаа шийдвэрлэсэн 3596, шийдвэрлэх шатандаа байгаа 36 өргөдөл, гомдол байна. Үүнээс Тээврийн бодлого, судалгааны хэлтэст 1855, Хяналт шалгалтын хэлтэст 1276, Зорчигч, тээврийн хэлтэст 160, Захиргаа, удирдлагын хэлтэс 251, Бүртгэл, техник, технологийн хэлтэст 31, Санхүү, аж ахуйн хэлтэст 36, Ачаа тээвэр, авто үйлчилгээний хэлтэст 23 өргөдөл, гомдол ирсэн байна. Шийдвэрлэлтийн байдлаар ангилбал: -Иргэний талд шийдвэрлэсэн 1872, -Бусад 44, -Боломжгүй тухай хариу өгсөн 1677, -Шийдвэрлэх шатандаа байгаа 36 өргөдөл, гомдол байна. 2024 онд 962 зөрчил тооцогдсоноос өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил 4574, өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил 186, явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил 201, буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй зөрчил 1, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 6 өргөдөл, гомдол байна. Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн дундаж хоног 6 хоног 08 цаг 28 минут байгаа нь нийслэлийн дундаж хоногт багтаан шийдвэрлэж байгаа үзүүлэлттэй байна.	100
18	Байгууллагын чиг үүргийн	10.Байгууллагуудын дотоод удирдлагын программын ашиглалт, үр дүн.	2024 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн байдлаар байгууллагын өглөөний шуурхай дээр тус байгууллагын газрын дарга болон, хэлтэс	70

Д/д	Бүлэг	Үзүүлэлт	Гүйцэтгэл, хүрсэн түвшин, үр дүн	Хувь
	үзүүлэлтийн үнэлгээ		нэгжийн даргаас өгсөн нийт 636 үүрэг даалгаврыг хэлтэс, нэгжүүдэд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын ERP программаар хуваарилснаас гүйцэтгэж байгаа 519, хугацаа хэтэрсэн 0, хянагдсан 117 үүрэг даалгавар байна.	
19	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	11.Байгууллагынхаа ажилтан, албан хаагчдын ажлын сахилга хариуцлага, байгууллагын соёл, дэг журмыг сахиулах, ажлын бүтээмжийг дээшлүүлсэн байдал, үр дүн.	2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 08:00 17:00 цаг байхаар тогтоосны дагуу байгууллагын албан хаагчдад танилцуулж, “ERP” цахим системд ажлын цагийн өөрчлөлт оруулан цаг ашиглалтад хяналт тавьж ажиллаж байна. Мөн Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үүргийн хэрэгжилтийг хангуулах талаар сургалтыг хуулийн ахлах зөвлөх зохион байгуулж ажилтан алба хаагчдыг хамруулсан. Тус газрын даргын шийдвэрээр төрийн захиргааны албан хаагчдад болон Хяналт шалгалтын хэлтсийн удирдлага, автотээврийн хяналтын улсын байцаагч нарт Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг нэг бүрчлэн хүргүүлж ажилласан.	100
Дундаж хувь:100%*18+70%*1				98.4

ТАНИЛЦСАН
ДАРГА:

/Д.ОТГОНЖАРГАЛ/

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

/З.ЦЭВЭЭНДОРЖ/

НЭГТГЭСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

/Ц.БЯМБАСҮРЭН/

